

ТАНИЛЦУУЛГА

“Журам батлах тухай” Засгийн газрын
тогтоолын төсөл боловсруулсан тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 21 дүгээр зүйлийн 21.30 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын болон журмын төслийг боловсрууллаа.

Энэхүү журмаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын “Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”-ийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч шимтгэл төлөх, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ -ийн 21 дүгээр зүйлийн 21.26, 21.27 дахь хэсэгт тус тус заасны дагуу цэргийн байгууллагад алба хаасан жилийг энгийн жилд шилжүүлж шимтгэл төлөх, дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчийн цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос батлан мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин, хөлс орлогоос нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг шилжүүлэн тооцох харилцааг зохицуулна.

Дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдын цаг уурын хүнд нөхцөл бүхий улсад ажилласан жилийн нэмэгдэл хугацаа, цэргийн алба хааж байсан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлд 2024 онд шаардагдах 518.0 сая төгрөгийн зардлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгасан болно.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 7.3.3-т заасан Монгол Улсын иргэний төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал) албан журмаар даатгуулах шимтгэлийн хэмжээг сарын 50 000 (тавин мянга) вонтой тэнцүү байхаар тогтоосон.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй болно.